



**ХЭНТИЙ АЙМГИЙН БОР-ӨНДӨР СУМЫН
ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН “ОЮУНЫ УУРХАЙ”
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2024 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 1/25

Бор-Өндөр сум

Сурах бичиг хүлээн авах ажлын хэсэг
байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/2487 дугаар албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсрол, шинжлэх ухааны газраас хуваарилсан 2024-2025 оны хичээлийн жилийн 1,3,4,5 дугаар ангийн сурах бичгийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:	Ц.Туяацэцэг	Нярав
Гишүүд:	Б.Анхчимэг	Нягтлан бодогч
	Б.Эрдэнэзул	Архив, бичиг хэргийн ажилтан
	Д.Эрдэнэчимэг	Эмч
	У.Эрдэнэ-Очир	Цахилгаанчин

2.Сурах бичиг хүлээн авах ажлыг холбогдох дүрэм журам, хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэхийг ажлын хэсэгт, сурах бичгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг нярав (Ц.Туяацэцэг), номын санч (Н.Нарантуяа) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ч.АМАРЖАРГАЛ